

Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулна



ЭРДЭНЭЧИМЭГ ЦАНДАТ

2015-12-16 17:48:51

НИЙГЭМ



Японы хамтын ажиллагааны нийгэмлэг Жайкагийн "Өвсний үндэс" техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах, тогтвортой систем байгуулах төсөл албан ёсны нээлтээ хийллээ. Эхний ээлжинд уг төслийг Сүхбаатар дүүргийн 71-р сургуулийн өсвөр үеийнхэнд хэрэгжүүлэхээр болж байна. Сүхбаатар дүүргийн гэр хорооллын бүсийн хувьд өсвөр наасны охидын жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдол харьцангуй олон бүртгэгджээ. Өсвөр үеийнхний хувьд сургууль дээрээ нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар болон хэрхэн эрүүл аж төрөх талаар хүссэн мэдээллээ авах боломж хомс байдаг байна. Харин энэхүү төсөл хэрэгжиж эхэлсэнээр сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу өсвөр наасны үе тэнгийн зөвлөхүүдийг бэлдэж бэлтгэгдсэн зөвлөхүүд үеийнхэндээ эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх юм.

Уг төслийн хүрээнд хийгдэх гол ажил бол өсвөр үеийнхний үе тэнгийн зөвлөхүүдийг бэлтгэх шаталсан сургалтууд юм. Эхний ээлжинд үе тэнгийн зөвлөхийн сургагч багшаар ажиллах тэдгээр хүмүүсийг сонгон Япон улсад сургалтанд хамруулах юм байна. Харин бэлтгэгдсэн сургагч багш нар Японы Жичи анагаах ухааны их сургуулийн багш настай хамтран Монголдоо үе тэнгийн зөвлөх бэлтгэх сургалтыг зохион байгуулах юм.